

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Боловсролын тухай хуулийн 36-р зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 11-ийн 26-р зүйлийг удирдлага болгон ХДС-ийн Удирдах зөвлөлийн (цаашид УЗ гэж товчлох) үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. ХДС-ийн Удирдах зөвлөл нь “Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургуулийн удирдах зөвлөл” гэсэн гарчиг, огноо бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.3. УЗ-ийн даргыг сонгох, өөрчлөх, гишүүнийг өөрчлөх, нөхөн сонгох ажиллагааг УЗ-ийн бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

1.4. УЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд гишүүдийн 75 хувиас доошгүй нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлаар олонхийн саналаар шийдвэр /тогтоол/ гаргаж, тэмдэглэл хөтөлнө.

ХОЁР. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

2.1 УЗ-ийн бүрэлдэхүүнд үүсгэн байгуулагчийн болон багшлах хамт олон, оюутан, хөрөнгө оруулагч, бизнесийн байгууллагын төлөөлөл байна.

2.2 Үүсгэн байгуулагч удирдах зөвлөл, түүний гишүүнийг хангалтгүй ажилласан гэж үзвэл өөрийн төлөөллөө эгүүлэн татах, бусад гишүүний талаар сонгосон хамт олонд нь мэдэгдэх эрхтэй.

2.3 Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл бүрэн эрхийн хугацаанд жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагч, зөвлөлийн дарга буюу гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар хуралдуулна.

2.4 Удирдах зөвлөл үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий комисс, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.5 Удирдах зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ;

2.5.1 холбогдох хууль тогтоомжийн дагуу ХДС-ийг хөгжүүлэх Бизнес төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, дүрмийг батлах, өөрчлөх;

2.5.2 сургуулийн бүтэц зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох;

2.5.3 хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж зарцуулалтанд хяналт тавих;

2.5.4 сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох;

2.5.5 сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх;

2.5.6 Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж үүсгэн байгуулагчид өгөх;

ГУРАВ. Удирдах Зөвлөл ба үүсгэн байгуулагчийн хамтын ажиллагаа

3.1 УЗ нь үйл ажиллагааны явц, үр дүнг үүсгэн байгуулагчийн өмнө тайлагнана. УЗ гарсан шийдвэрийнхээ талаар үүсгэн байгуулагчийн өмнө хариуцлага хүлээнэ.

3.2 Үүсгэн байгуулагч нь УЗ дахь өөрийн төлөөллийн талаар үнэлэлт дүгнэлт өгч, үйл ажиллагааны зохих чиглэл өгнө.

ДӨРӨВ. Бусад зүйл

- 4.1. УЗ-нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй
- 4.2. УЗ-ийн албан хэрэгт шаардлагатай бол ХДС-ийн тэмдэг хэрэглэж болно.
- 4.3. УЗ-ийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн зардлыг сургуулийн жилийн төсөвт тусган зарцуулна.